



Төрийн өмчийн хорооны 2007 оны 42 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН ӨӨРИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨРИЙН ДООД ҮНЭ

1.Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрийн санхүүгийн тайлан балансад тусгагдсан төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг бусад өмчийн хуулийн этгээд, иргэдэд түрээслүүлэх төлбөрийн доод үнийг салбарын ангилал, үйл ажиллагааны чиглэлийг харгалзаа доорхи байдлаар тогтооно.

1.1 Түрээсийн төлбөрийн 1 м2 ашигтай талбайн доод үнэ/төг/

д/д		Түрээсийн төлбөрийн доод үнэ/төг/
1.	Боловсрол, соёл шинжлэх ухааны салбар	5000
2.	Үйлдвэрлэл	8000
3.	Худалдаа, үйлчилгээ	7000
4.	Аялал, жуулчлал, энэ чиглэлийн худалдаа	7500
5.	Нийтийн хоол	6500
6.	Эрүүл, мэндийн үйлчилгээ	5500
7.	Олон нийтийн байгууллага	4500
8.	Барилгын зураг төсөл	6500
9.	Геодези, зураг зүйн үйлдвэрлэл	8000
10.	Үсчин, гоо сайхан, ахуйн үйлчилгээ	7500
11.	Санхүүгийн үйлчилгээ	8500
12.	Бусад	5500

2. Хотын захын хороололд байршилтай эд хөрөнгө болон туслах талбайг

түрээслүүлэхэд түрээсийн төлбөрийн доод үнийг 30-40 хүртэл хувиар бууруулан тогтоож болно.

3. Төрийн өмчийн бүртгэлд байгаа ашиглалтгүй барилга байгууламжийг түрээслэгчийн зардлаар засаж сэлбэн түрээслүүлэхэд 1.1-д заасан салбарын ангилал, үйл ажиллагааны чиглэлээр тогтоосон түрээсийн төлбөрийн доод үнийг 20 хувиар бууруулан тогтоож болно.

4. Төрийн өмчийн байранд байрлаж буй төсөвт байгууллага, албан газрын ашиглаж байгаа өрөө тасалгааны 1 ам. метр ашигтай талбайн түрээсийн төлбөрийг Сангийн яамнаас болон холбогдох эрх бүхий байгууллагаас тухайн хуулийн этгээдэд баталж өгсөн ашиглалтын болон байрны түрээсийн зардалд үндэслэн тогтооно.

5. Төрийн өөрийн өмчийн хөдлөх хөрөнгийн түрээсийн төлбөрийг тогтоохдоо ашиглалт үйлчилгээнд зарцуулах зардал болон хөдлөх хөрөнгийн эдэлгээний нормыг харгалзан түрээсийн төлбөрийн доод хэмжээг тогтооно.

6. Төрийн оорийн өмчийн байр талбайд суурилуулсан реклам чимэглэлийн түрээсийн төлбөрийг өнөөгийн зах зээлийн үнэд тулгуурлан түрээслүүлэгч, түрээслэгч нар харилцан тохиролцсоны үндсэн дээр тогтоож болно.

7. Төрийн оорийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод үнийг салбарын онцлогоос шалтгаалан өөрчлөх шаардлага гарвал Төрийн өмчийн хороо Сангийн яамны саналыг авч шийдвэрлэнэ.

-----oOo-----